



НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Төсөл буцаах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит долоодугаар хуралдаанаар Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Майхан толгойд хэрэгжүүлэх “Ногоон хөндий” зөгийн аж ахуйн төслийг хэлэлцээд төсөл хэрэгжүүлэх газар нь дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 06 дугаар тогтоолоор баталсан орон нутгийн тусгай хамгаалалтад авсан бүсэд хамаарч байгаа тул хуралд оролцсон Төлөөлөгчдийн 76,1 хувийн саналаар дэмжихээс татгалзав.

ДАРГА

Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100013





НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Газрын үнэлгээний зэрэглэл (бүс)-ийн газрын  
төлбөр тооцох итгэлцүүрийн тоон утга,  
түүнийг хэрэглэх газрын зааг,  
хязгаарыг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.д заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 1, 2 дугаар заалтыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрийн газрын үнэлгээний зэрэглэл (бүс)-ийн газрын зааг, хязгаарыг /солбицол, газрын зааг хязгаарын зураг/ нэгдүгээр, газрын төлбөр тооцох итгэлцүүрийн тоон утгыг хоёрдугаар, хөдөө аж ахуйн газрын төлбөрийн итгэлцүүрийн тоон утгыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Газрын төлбөрийн төлөвлөгөөний биелэлт, нийслэлийн төсвийн орлого бүрдүүлэх, газрын төлбөр хуримтлуулах, газрын төлбөрийн хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотой иргэдэд сурталчлах ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 01 дүгээр сарын 30-ний өдрийн 08 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ











1150100016



# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВГЭРТ ТӨЛБӨР ТООЦОХ ИТГЭЛЦҮҮР ХЭРЭГЛЭХ ГАЗРЫН ЗААГ, ХЯЗГААРЫН ЗУРАГ



## ТАНИХ ТЭМДЭГ

	1		5
	2		6
	3		7
	4		9

1:45,000





Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн  
08 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт


Газрын төлбөр тооцох итгэлцүүрийн тоон утга  
/1м.кв газарт ногдуулах газрын төлбөрийн хэмжээ/

№	Газар ашиглалтын ангилал	1-р бүс			2-р бүс			3-р бүс			4-р бүс		
		3Г-ын 182 тогтоолоор суурь үнэ /1га сая.төг/	итгэлцүүр	1 м2 газрын төлбөр, төг	3Г-ын 182 тогтоолоор суурь үнэ /1га сая.төг/	итгэлцүүр	1 м2 газрын төлбөр, төг	3Г-ын 182 тогтоолоор суурь үнэ /1га сая.төг/	итгэлцүүр	1 м2 газрын төлбөр, төг	3Г-ын 182 тогтоолоор суурь үнэ /1га сая.төг/	итгэлцүүр	1 м2 газрын төлбөр, төг
1	Гэр бүлийн хамтын хэрэгцээ	818	0.23	192	764	0.24	183	490	0.24	118	436	0.24	105
2	Төсөвт байгууллага	323.8	0.65	210	220.8	0.90	199	176.6	0.80	141	132.5	0.90	119
3	Нийтийн зориулалттай орон сууц	957.4	0.90	862	652.8	0.95	620	522.2	1.00	522	391.6	1.00	391.6
4	Худалдаа бүх төрлийн үйлчилгээ	1280	1.00	1280	1216	1.00	1216	1216	1.00	1216	1152	1.00	1152
5	Нефьт бүтээгдэхүүний агуулах шатахуун түгээх станц	1408	1.00	1408	1344	1.00	1344	1280	1.00	1280	1216	1.00	1216
6	Бүх төрлийн авто зогсоол/ газар дээрх доорх/	960	1.00	960	768	1.00	768	576	1.00	576	576	1.00	576
7	Нийтийн эдэлбэрийн газар	380.2	1.00	380	259.2	1.00	259	207.4	1.00	207	155.5	1.00	155.5
8	Инженерийн шугам сүлжээ түүний дэд бүтэц байгууламж	957.4	0.30	287	652.8	0.30	196	522.2	0.30	157	391.7	0.30	118
9	Төмөр зам нисэх онгоцны буудлын барилга байгууламж	957.4	0.40	383	652.8	0.55	359	522.2	0.60	313	391.7	0.70	274
10	Төмөр зам нисэх онгоцны буудлын хамгаалалтын бүс	366.1	0.50	183	249.6	0.70	175	199.7	0.80	160	149.8	0.95	142
11	Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар	760.3	0.70	532	518.4	0.90	467	414.7	0.90	373	311	0.90	280
12	Шашин сүм хийд	1309.5	0.80	1048	892.8	0.95	848	714.3	0.95	679	535.6	0.95	509
13	Химийн хорт бодис арьс шир ноос ноолуурын үйлдвэр цэвэрлэх байгууламж болон аюултай хог хаягдлын үйлдвэр	1408	1.00	1408	1344	1.00	1344	1280	1.00	1280	1216	1.00	1216
14	Бүр төрлийн үйлдвэрлэл/ хөдөө аж ахуйгаас бусад/	1408	0.75	1056	1344	0.70	941	1280	0.60	768	1216	0.50	608
15	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
16	Уул уурхайн олборлолт хийж буй газар	-	-	-	1408	1.00	1408	1344	1.00	1344	1280	1.00	1280
17	Уул уурхайн эдэлбэрийн үйлдвэрлэлийн газар	-	-	-	1408	1.00	1408	1344	1.00	1344	1280	1.00	1280






№	Газар ашиглалтын ангилал	5-р бүс			6-р бүс			7-р бүс			9-р бүс		
		ЗГ-ын 182 тогтоолоор суурь үнэ /1га сая.төг/	итгэлцүүр	1 м2 газрын төлбөр, төг	ЗГ-ын 182 тогтоолоор суурь үнэ /1га сая.төг/	итгэлцүүр	1 м2 газрын төлбөр, төг	ЗГ-ын 182 тогтоолоор суурь үнэ /1га сая.төг/	итгэлцүүр	1 м2 газрын төлбөр, төг	ЗГ-ын 182 тогтоолоор суурь үнэ /1га сая.төг/	итгэлцүүр	1 м2 газрын төлбөр, төг
1	Гэр бүлийн хамтын хэрэгцээ	382	0.24	92	273	1.00	273	245	0.27	66	136	0.35	48
2	Төсөвт байгууллага	132.5	0.85	113	117.8	1.00	118	103	0.80	82	58.8	0.80	47
3	Нийтийн зориулалттай орон сууц	391.6	1.00	392	348.2	1.00	348	304.6	0.80	244	174.1	1.00	174
4	Худалдаа бүх төрлийн үйлчилгээ	1088	0.70	762	960	1.00	960	896	0.64	576	896	0.40	358
5	Нефьт бүтээгдэхүүний агуулах шатахуун түгээх станц	1216	1.00	1216	1152	1.00	1152	1088	0.90	979	896	1.00	896
6	Бүх төрлийн авто зогсоол/ газар дээрх доорх/	512	1.00	512	448	1.00	448	384	0.58	224	384	1.00	384
7	Нийтийн эдэлбэрийн газар	155.5	1.00	156	138.2	1.00	138	121	0.57	69	69.1	0.90	62
8	Инженерийн шугам сүлжээ түүний дэд бүтэц байгууламж	391.7	0.30	118	348.2	1.00	348	304.6	0.34	104	174.1	0.40	70
9	Төмөр зам нисэх онгоцны буудлын барилга байгууламж	391.7	0.70	274	348.2	1.00	348	304.6	0.46	139	174.1	0.50	87
10	Төмөр зам нисэх онгоцны буудлын хамгаалалтын бүс	149.8	0.90	135	133.1	1.00	133	116.5	0.80	93	66.6	0.40	27
11	Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар	311	0.90	280	276.5	1.00	277	241.9	0.80	194	138.2	1.00	138
12	Шашин сүм хийд	535.6	0.90	482	476.1	1.00	476	416.7	0.69	286	238	0.60	143
13	Химийн хорт бодис арьс шир ноос ноолуурын үйлдвэр цэвэрлэх байгууламж болон аюултай хог хаягдлын үйлдвэр	1216	1.00	1216	1152	1.00	1152	1088	0.85	922	896	1.00	896
14	Бүр төрлийн үйлдвэрлэл/ хөдөө аж ахуйгаас бусад/	1216	0.45	547	1152	1.00	1152	1088	0.32	346	896	0.12	108
15	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	-	-	-	-	-	-	-	-	-	64	1.00	64
16	Уул уурхайн олборлолт хийж буй газар	1216	1.00	1216	1216	1.00	1216	1152	0.84	973	1024	1.00	1024
17	Уул уурхайн эдэлбэрийн үйлдвэрлэлийн газар	1216	1.00	1216	1216	1.00	1216	1152	0.84	973	1024	0.60	614




## Тайлбар:

Энэ хавсралтад заасан газар ашиглах зориулалтыг дараах байдлаар ойлгоно:

- “Гэр бүлийн хамтын хэрэгцээний” гэдэгт Газрын тухай хуулийн 29.1, 29.2-т заасан газар;
- “Төсөвт байгууллагын албан хэрэгцээ” гэдэгт улс, орон нутгийн төсвөөс санхүүждэг төрийн байгууллага, бүх шатны сургууль, цэцэрлэг, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага, номын сан, биеийн тамир спорт, соёл, урлагийн байгууллага, тэдгээрийн барилга байгууламж, оффисын газар;
- “Нийтийн зориулалттай орон сууц” гэдэгт нэгдсэн төлөвлөлтийн дагуу баригдаж буй нийтийн зориулалттай орон сууцны газар;
- “Худалдаа бүх төрлийн үйлчилгээ” гэдэгт бүх шатны сургууль, цэцэрлэг, эмнэлэг, номын сан, биеийн тамир спорт, соёл урлагийн байгууллага, тэдгээрийн барилга байгууламж, оффис, үйлдвэрлэл-үйлчилгээ зэрэг холимог зориулалтаар ашиглагдаж буй газар, худалдааны төв, дэлгүүр, зочид буудал, нам, төрийн бус байгууллага, амралт сувиллын газар, аялал, жуулчлалын үйлчилгээний зориулалттай газар болон бусад;
- “Нефтийн бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц” гэдэгт хийн түлш, шатахуун түгээх станц, нефтийн бүтээгдэхүүний агуулахын газар;
- “Бүх төрлийн авто зогсоол (гараж) барих (газар дээрх, доорх)” гэдэгт авто гараж, авто зогсоолын газар;
- “Нийтийн эдэлбэрийн газар” гэдэгт амралт-зугаалга, биеийн тамир, цэцэрлэгт хүрээлэн, гудамж, талбай, зам, оршуулгын зориулалттай газар;
- “Инженерийн шугам сүлжээ, түүний дэд бүтцийн барилга байгууламжийн газар” гэдэгт холбооны шугам, холбооны мэдээлэл хүлээн авах станцын эзлэх талбай, эрчим хүчний шугам, станцын эзлэх талбай, ус, дулаан дамжуулах хоолойн эзлэх талбай, ус шахах, өргөх байгууламж, үерээс хамгаалах далан, сувгийн доорх газар;
- “Төмөр зам, нисэх онгоцны буудлын барилга байгууламж” гэдэгт төмөр зам, нисэх онгоцны буудлын барилга байгууламжийн газар;
- “Төмөр зам, нисэх онгоцны буудлын хамгаалалтын бүс” гэдэгт төмөр зам, нисэх онгоцны буудлын хамгаалалтын бүс тогтоосон газар;
- “гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар” гэдэгт Газрын тухай хуулийн 16.1.4-т заасан газар;
- “Шашин, сүм, хийд” гэдэгт шашин, сүм хийдийн зориулалттай газар;
- “Химийн хорт бодис, арьс, шир, ноос, ноолуурын үйлдвэр, цэвэрлэх байгууламж болон аюултай хог хаягдлын үйлдвэр” үйлдвэрлэлийн олборлолт, боловсруулалтад химийн хорт бодис, аюултай хог хаягдал үүсгэдэг, ялгаруулдаг арьс, шир, ноос, ноолуурын үйлдвэр, цэвэрлэх байгууламж болон тэдгээртэй адилтгахуйц үйлдвэрлэлийн зориулалттай газар;
- “Бүх төрлийн үйлдвэрлэл (хөдөө аж ахуйгаас бусад)” гэдэгт хөдөө аж ахуйн үйлдвэрлэл болон хүнд үйлдвэрлэлээс бусад үйлдвэрийн газар;
- “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл” гэдэгт эрчимжсэн мал аж ахуйн болон хөдөө аж ахуйн зориулалттай барилга байгууламж, хүлэмжийн аж ахуй, газар дээрх, доорх зоорь, Газрын тухай хуулийн 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү талбайд тариалж буй төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, таримал ургамал тариалахад зориулсан хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай газар;
- “Уурхайн эдэлбэрийн олборлолтын талбай” гэдэгт Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.18-д заасан газар;
- “Уурхайн эдэлбэрийн үйлдвэрлэлийн газар” гэдэгт уурхайн үйлдвэрлэлийн зориулалттай барилга, байгууламжийн газар.







Хөдөө аж ахуйн газрын үнэлгээний тойргийн  
1 га газрын төлбөрийн итгэлцүүрийн тоон утга

Тойргийн дугаар	Газрын үнэлгээний тойргийн индекс	Бэлчээр		Тариалан			Хадлан			
		1 га газрын суурь үнэлгээ мян. төг	1 хонин толгойд ноогдох жилийн төлбөрийн хэмжээ, төг	1 га газрын			Ангилал	1 га газрын		
				Суурь үнэлгээ мян. төг	Итгэлцүүр, хувь	Жилийн төлбөрийн хэмжээ, төг		Суурь үнэлгээ мян. төг	Итгэлцүүр, хувь	Жилийн төлбөрийн хэмжээ, төг
Х-9	Хэнтийн зах хаяа уулсын ойт хээрийн тойрог	907,2	272,2	4704,0	0.03	1411,0	Уулын нуга	3024,0	0.03	907,0


Тайлбар:

“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл”-д хот суурин газар, хот орчмын ногоон бүс буюу газрын үнэлгээний бүсчлэлийн 8, 9, 10, 11 дүгээр бүсэд байрлах хүлэмжийн аж ахуй, мал аж ахуй, иргэний ахуйн хэрэгцээнээс илүү талбайд тариалж буй төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалттай газар хамаарна,

Жич: 1-7 дугаар бүсэд “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл”-д хамаарах зориулалтаар газар эзэмших эрх авсан этгээдийн газрын төлбөрийг “Бүх төрлийн үйлдвэрлэл” зориулалтаар тооцон авна.

“Хөдөө аж ахуйн газар”-т хот суурин газар, хот орчмын ногоон бүсээс гадна, газрын үнэлгээний бүсчлэлийн 10, 11 дүгээр бүс /зарим хэсэг/, 12, 13, 14, 15, 16 дугаар бүсэд байрлах Газрын тухай хуулийн 11 дүгээр зүйл, Тариалангийн тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан газар хамаарна.







НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

2019 оныг “Иргэдийнхээ хөгжлийг дэмжих жил”  
болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Иргэний хууль эрх зүй, эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухаан танин мэдэхүйн боловсролыг дээшлүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд чанартай хүртээмжтэй үйлчилгээг хүргэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар ажилтай орлоготой болгох, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг тэгш хүртээмжтэй хүргэх зорилгоор 2019 оныг “Иргэдийнхээ хөгжлийг дэмжих жил” болгон зарласугай.

2. 2019 оныг “Иргэдийнхээ хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан төрийн байгууллагын шийдвэр гаргах түвшний үйл ажиллагаанд иргэний оролцоог нэмэгдүүлэн саналыг тусган ажлын төлөвлөгөө баталж, төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах зэргээр салбар хоорондын уялдаа холбоог хангаж, олон талт ажлыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнан ажиллахыг дүүргийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/- д даалгасугай.

3. Жилийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааг олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/, Засаг даргын Тамгын газар /А.Дамцагдорж/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100023

